

СОЁМБО МЭДЭЭ

/ТУСГАЙ ДУГААР/

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.07.01 №86 (86)



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХОЛБООНЫ ЦЭРГИЙН ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ӨРГӨН ДЭВШҮҮЛЬЕ

МЭНДЧИЛГЭЭ



Монгол Улсад орчин цагийн Цэргийн холбоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын мэндийг үе үеийн цэргийн холбоочид, эрхэм генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан алба хаагч Та бүхэнд дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Эртний Хүннү гүрний “Уургийн улаа”, Их Монгол Улсын “Өртөө”-нөөс улбаатай орчин цагийн Зэвсэгт хүчний цэргийн холбоо анх 1921 онд Ардын засгийн Цэргийн яам байгуулагдан Ардын журамт цэргийн харилцаа холбооны ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэй “Харилцан нэвтрэлцэх хэлтэс” байгуулагдсанаас хойш даруй 100 дахь жилийнхээ ойттой золгож байна.

Цэргийн холбооны 100 жилийн түүх нь улс орныг батлан хамгаалах, зэвсэгт хүчний хөгжлийн түүхтэй салшгүй холбоотой. Цэргийн холбоочид 1921 оны Ардын хувьсгалын үр дүнд туурга тусгаар Монгол Улсаа байгуулах, Халхын голын 1939 оны байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр болсон зэвсэгт тулгаралтын ялалтыг авчрах үйл хэрэгт онцгой үүрэг гүйцэтгэснийг юуны өмнө цохон тэмдэглэж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн холбоо нь тэртээх 1921 онд анхлан ашигласан телеграфын холбооноос эхлээд радио, радиорелейний холбоо, өнөө үеийн тоон системд суурилсан холбоо, мэдээллийн технологийг ашиглах хүртэл хөгжин дэвшиж, Монголын Ардын Хувьсгалт Цэрэг, Монголын Ардын Арми, Монгол Улсын Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэг, цар хүрээ өсөхийн хэрээр түүний удирдлагыг шуурхай, боловсронгуй болгох, удирдлага, холбооны бэлэн байдлыг

хангах хариуцлагатай үүргийг цэргийн холбоочид мадаггүй сайн биелүүлж ирснийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Өнөөдөр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030-д туссан “Цэргийн удирдлага, холбоо, мэдээллийн хэрэгслийг шинэчлэх” зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний холбоо, мэдээллийн суурь сүлжээг өндөр хурдны өргөн зурвасын тоон техник, технологид шилжүүлэх”, “Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын хэргийн холбооны зангилгааны техник хэрэгслийг шинэчлэх, тактикийн түвшний салбарыг холбоожуулах” гэсэн арга хэмжээг тусган “Нэгдсэн сүлжээ-шилэн кабель”, “Хээрийн хөдөлгөөнт радио холбоо” төслүүдийг ирэх 2022 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэснийг дуулгахад таатай байна.

Түүнчлэн дэлхий нийтэд өрнөж буй дижитал шилжилт буюу цахим хувьсгалтай манай цэргийн холбооны инженер, техникийн ажилчид хөл нийлүүлэн “Радио электроникийн хэрэгсэл зохион бүтээх судалгаа, туршилтын төв”-ийг байгуулан богино долгионы радиостанцын анхны загварыг бүтээх ажлыг амжилттай хэрэгжүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд манлайлан оролцож байгаа нь бахархууштай.

Зэвсэгт хүчний холбоо, удирдлагын автоматжуулсан системийн бэлэн байдлыг хангах, тоон технологид шилжүүлэх, нэгтгэл, анги, салбаруудын орчин үеийн цэрэг, зэвсгийг удирдах холбоо, мэдээллийн техник хэрэгслийг шинэчлэхээр өмнөө дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж, үр дүн гаргахын төлөө цэргийн холбоочид маань хичээн ажиллаж, илүү хариуцлагатай хандана гэдэгт Сайд миний бие огт эргэлзэхгүй байна.

Цэргийн холбооны хөгжилд хувь нэмрээ оруулж яваа цэргийн холбоочид Та бүхэндээ орчин цагийн цэргийн холбоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баярын чин сэтгэлийн халуун мэндийг дахин хүргэж, өмнө гаргасан ололт, амжилтаа бататгаж, цэргийн холбооны ирээдүйн хөгжил, цэцэглэлтэд улам их хувь нэмэр оруулах өрөөлийг өргөн дэвшүүлж!

Монгол цэргийн сүр жавхаа, сүлд хийморь мөнхөд мандан бадарч байх болтугай.

Эрхэм генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч, ажилтан алба хаагчид, дэлхийн халуун цэгүүдэд үүрэг гүйцэтгэж байгаа энхийг сахиулагчид, эх орноо батлан хамгаалах үйлсэд эрдэм ухаан, хөдөлмөр зүтгэлээ зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэнд Зэвсэгт хүчний холбооны цэргийн түүхт 100 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлж!

Эх орон, ард түмнийхээ бүрэн эрхт байдал, тусгаар тогтнол, нэгдмэл байдлыг хамгаалах, олон улсад хүлээн зөвшөөрүүлэх, хамгаалан бататгах нэн шинэ үеийн эхлэлийг тавьсан Монгол ардын журамт цэргийн бүрэлдэхүүнд Харилцан нэвтрэлцэх хэлтсийг 1921 оны сүүлийн хагаст байгуулснаар орчин цагийн Зэвсэгт хүчний цэргийн холбооны түүх эхэлсэн билээ. Тодруулбал, Монгол ардын журамт цэргийн гол хүч 1921 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Их хүрээнд орж ирсний дараа Жанжин Д.Сүхбаатарын байрлаж байсан майханд Хиагт хотыг Их хүрээтэй холбосон утас холбооны телефон шугамын үзүүрийг оруулан анхны цэргийн зориулалт бүхий холбоог тогтоосноор энэхүү түүхийн алтан хуудас нээгдсэн юм.

Цэргийн холбооны түүхт ой нь Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110, Ардын хувьсгалын 100, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 110, орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ой зэрэг түүхэн тэмдэглэлт баяр тохиосон жил болж буйгаараа ихээхэн онцлогтой.

Энэхүү баярын өдөр Ардын хувьсгалтайгаа эн чацуу өндөр насны босгыг давж буй 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин, Монгол Улсын анхны Онц холбоочин, чөлөөнд байгаа дэд хурандаа Т.Бат-Очир Танд онцгойлон баяр хүргэж, эрүүл энх, урт удаан наслахын өрөөлийг өргөн алтгаж.

Аливаа түүхт ойг тэмдэглэх нь өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа дүнгэн цэгнэх, өнөөгийн бодит байдалд дүн шинжилгээ хийх, цаашдын зорилго, зорилтоо тодорхойлох чухал ач холбогдолтой. Цэргийн холбоочид нь Ардын хувьсгалын он жилүүдэд, Халхын голын байлдаан болон Чөлөөлөх дайны хүнд хэцүү цагийн байдалд, дайны дараах энх цагийн бүтээн байгуулалтад, олон улсын энхийг дэмжих ажиллагаанд, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад, олон улсын хамтарсан сургалт, уралдаан тэмцээн, хээрийн сургууль, дадлагын үеийн холбоо, мэдээллийг амжилттай зохион байгуулж, төр, засаг, цэргийн дээд командлалаас тавигдсан үүргийг мадаггүй биелүүлсээр ирсэн нь бидний бахархал юм.

Түүхэн зуун жилийн хугацаанд цэргийн холбоочдоос БНМАУ-ын баатар М.Жанчив, хошууч генерал С.Гангааням, Р.Гаваа, Д.Мягмар, М.Борбаатар, бригадын генерал Ч.Сосорбарам, П.Пүрэвбазар, Батлан хамгаалахын сайд Ш.Түвшэндорж, гавьяат холбоочин, хурандаа Д.Рэнцэнханд, гавьяат багш, хурандаа Д.Санжсүрэн, доктор, профессор, хурандаа Б.Равжаа, Г.Сүхээ, А.Түвшинтөгс, Д.Батболд, Ц.Хүрэл зэрэг олон алдартнууд төрснийг баярын энх өдөр онцлон тэмдэглэхэд таатай байна.

Тэрчлэн тэдний үлгэр дуурайл, бүтээлч үйл ажиллагааг залгамжлан шинэ үеийн технологийн радио станцыг бүтээсэн хурандаа Л.Батболд, Р.Энхнасан, өндөр хурдны радиотелеграфын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс анхны хүрэл медалийг хүртсэн сургагч ахлагч



Ц.Болдбаатар, радио спортын дэлхийн аваргын хүрэл медальт, доктор, хошууч Л.Олмаа, доктор, хурандаа М.Батхуяг, дэд хурандаа Ц.Эрдэнэтуяа, Б.Хандсүрэн, энхийг дэмжих ажиллагаанд анхны мөрийг гаргагчдын тоонд нэрлэгдэх хурандаа Ч.Ерөөцэнгэл, хурандаа Г.Болор, Н.Нямжаргал, залуу зохион бүтээгч ахлах дэслэгч Ж.Бямбадорж, цэргийн мэргэжлийн аварга, дэслэгч Б.Нангид нарын олон алдартан тодорсоор байгааг ч онцлох учиртай.

Өнөөдөр цэргийн холбоочдын өмнө Зэвсэгт хүчний холбоо, цэргийн удирдлагын автоматжуулсан систем, хэрэгслийн бэлэн байдлыг хангах, орчин үеийн тоон технологиор шинэчлэх, мэдээллийн сан, программ хангамжуудыг шинээр зохион ашиглах, холбоочдын үүрэг гүйцэтгэх чадавх, мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх, холбоо, мэдээллийн техник хэрэгсэлд хийгдэх засвар, техникийн үйлчилгээг технологийн дагуу хийх, Зэвсэгт хүчинд төрийн болон цэргийн нууцыг чанд хадгалах, хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, Зэвсэгт хүчний анги, салбарууд, гадаадад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багуудтай мэдээллийн харилцааг тасралтгүй зохион байгуулах зэрэг олон зорилго, зорилт тавигдаж байна.

Эдгээр зорилго, зорилтуудыг амжилттай шийдвэрлэх, цэргийн шинэчлэлийн бодлогыг эрчимжүүлэх, Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үндсэн болон бусад үүргүүдийг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх, холбоо, мэдээллийн сүлжээ, систем, хэрэгслийг тоон технологид бүрэн шилжүүлэх, холбооны анги, салбарууд, бие бүрэлдэхүүний мэргэжлийн дадлага, ур чадварыг дээшлүүлэх, сургалт бэлтгэлийн чанарыг ахиулах, цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, ахуй хангалт, ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зэрэг Та бүхний бүтээлч үйл ажиллагаанд бид байнгын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах болно.

Зэвсэгт хүчний холбоо, мэдээллийн бэлэн байдлыг хангахад залуу нас, хүч хөдөлмөрөө зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, холбоо, мэдээллийн системийн ирээдүйн хөгжлийн төлөө амжилт дүүрэн зүтгэж яваа офицер, ахлагч, ажилчин албан хаагчид, цэргийн гэрээт болон хугацаат албаны түрүүч, байлдагч нартаа цэргийн холбооны түүхт 100 жилийн ойн баярын мэндчилгээг дахин дэвшүүлж, ажил, албаны арвин их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн өрөөе.

Монгол цэргийн яруу алдар, сүр хүч, сүлд хийморь мандан бадрах болтугай!

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
11	6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
29	22

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
33	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.844.00	2.855.00
EUR	3.363.00	3.423.00
CNY	438.60	442.40
RUB	38.60	40.30
JPY	25.48	25.97
KRW	2.43	2.57

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 22
2021.07.01.
/ПҮРЭВ ГАРАГ/

ЗУНЫ ДҮНД ХӨХ МОРЬ САР ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Идээг ундаа элбэг олдно

Наран ургах, шингэх:
04:57-20:55

Барилдлага:

Үл зохилох

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

Суудал:

Мод

Аргын тооллын 2021 оны долдугаар сарын 1, Пүрэв гараг.

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. Муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр, эд хураах, номын өөлөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

115.478

ЭДГЭРСЭН

76.654

НАС БАРСАН

563/15

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

3404 (58)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

327

ЭДГЭРСЭН

3017

ТА ӨӨРТ ТОХИРОХ ВАКЦИНЫГ ТАРИУЛААРЙ

Вакцин Вероселл, АстрЗенека, Комирнати

Вяэр нэг шалтгааны улмаас КОВИД-19 өвчний эсрэг вакцинад хамрагдаагүй 18-с дээш насны иргэд дархлаажуулалтын цэгт очиж энэцэд үзүүлэн өөрт тохирох вакциныг тариулах боломжтой болно!

ЛУХАЙН ВАКЦИН ТАРЖ БҮЙ ЦЭГТ ОЧНО!

КОРОНАВИРУС КОВИД-19 ХАЛДВАРААС СЭРГИЙЛБЭ!

Хүүхдийг КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)- ААС СЭРГИЙЛБЭ!



ЦЭРГИЙН ХОЛБООЧДЫН 100 ЖИЛИЙН ДАЙЧИН УЛАМЖЛАЛ, ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ

(Цэргийн холбооны 100 жилийн ойн баярын цахим хурлын илтгэл)
Зэвсэгт хүчний Жанжин штабын Холбоо, мэдээллийн технологийн хэлтсийн дарга, хурандаа М.Золзаяа

Хүндэт зочид оо!
Эрхэм генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилтан албан хаагчид аа!
Үе үеийн цэргийн холбоочид оо!
Бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад холбоочин дайчид аа!

Цэнхэр дуулгалан - энхийг сахиулагч холбоочид оо!
Монгол цэргийн, түүний дотор, цэргийн холбоочдын түүхэн тэмдэглэлт энэ өдөр бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, нийт бие бүрэлдэхүүн, тэдний хүндтэй бөгөөд хариуцлагатай албыг дэмжин сайшааж байдаг найдвартай ар тал болсон гэр бүлд нь Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлагын нэрийн өмнөөс чин сэтгэлийн баярын мэнд хүргэе.

Монгол эх орныхоо өнцөг булан бүрт, гадаад улс орнуудад энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж яваа Зэвсэгт хүчний холбоочин цэргийн алба хаагчид орчин цагийн Зэвсэгт хүчинд Цэргийн холбоо үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярын мэнд дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе.

Хүннү гүрний үеэс улбаатай уургийн улаач, морин өртөөнөөс морзын үсэг - өгөгдөхүүн нэвтрүүлэх - тоон техник, технологийг эзэмшсэн цэргийн холбоочид «Өнгөрсөн түүхийг сургаж, өнөө үеийг боломж, ирээдүйг бэлэг» хэмээн ойлгож, өнгөрсөн, одоо, ирээдүй 3 цагийн алтан холбоосыг Эзэн Чингис хааны алтан эргээр мөнхөлсөн бахархалт түүхийг бүтээгчид билээ.

Монгол цэргийн харилцаа холбоо нь эртний Хүннү гүрний үеийн "Уургийн улаа" хэмээх харилцааны үндсэн арга хэлбэрээс "Өртөө" хэмээх эзэнт гүрний хэмжээний шуудан холбооны гол арга хэрэгслийг үүсгэн өрнө, дорныг холбосон холбооны нэг бүхэл бүтэн тогтолцоо болтлоо хөгжиж,

өглөөний 9 цагт Их Хүрээнд орж ирээд Их жанжин Д.Сүхбаатарын байрлаж байсан майханд Хиагт хотыг Их Хүрээтэй холбосон утсан холбооны шугамын үзүүрийг холбоочин Доржийн Бадарчин оруулж, анхны цэргийн зориулалтын холбоог тогтоосноороо Монгол цэргийн шинэ цагийн холбооны түүхийн алтан хуудас нээгдсэн гэдгийг Та бид сайн мэдэх билээ.

Цэргийн холбооны түүхийг 100 жилийн өндөрлөгөөс эргэн харж, улсын болон Зэвсэгт



хүчний хөгжлийн үе шатуудтай уялдуулан

1. 1921-1929 онд - МАХЦ-ийн холбоо үүссэн үе
2. 1930-1945 онд - Цэргийн холбооны хөгжил бэхжилтийн үе
3. 1946-1964 онд - Дэлхийн хоёрдугаар дайны дараах жилүүдийн цэргийн холбооны хөгжлийн үе
4. 1965-1989 онд - МАА-ийн цэргийн холбооны үе
5. 1990-2000 онд - Холбооны цэргийн хөгжлийн шинэ үе
6. 2001 оноос шинэ цагийн Зэвсэгт хүчний цэргийн холбоо, мэдээллийн технологийн үе хэмээн тодорхойлж байна.

Цэргийн холбоочид нь Ардын хувьсгалын он жилүүдэд, Халхын голын байлдаан болон чөлөөлөх дайны үед, дэлхийн

нь холбооны цэргийн түүхэн уламжлал, үнэт зүйл, түүхэнд тэмдэглэгдсэн тод томруун үйл хэрэг болон дурсагдан үлдэж байна.

Энэхүү түүхэн 100 жилийн хугацаанд Цэргийн холбоочдын эгнээнээс Монгол Улсын баатар М.Жанчив, Халх голын дайнд оролцсон Зэвсэгт хүчинтэйгээ нас чацуу ахмад холбоочин дэд хурандаа Т.Бат-Очир, хошууч генерал С.Гангааням, Р.Гаваа, Д.Мягмар, М.Борбаатар, бригадын генерал



Ч.Сосорбарам, П.Пүрэвбаатар, Батлан хамгаалахын сайд Ш.Түвэндорж, гавьяат холбоочин, хурандаа Д.Рэнцэнханд, гавьяат багш, хурандаа Д.Санжсүрэн, доктор, профессор, хурандаа Б.Равжаа, Г.Сүхээ, А.Түвшинтөгс, Д.Батболд, Ц.Хүрэл зэрэг ард олондоо дурсагдсан алдар гавьяатнууд төрөн гарсныг баярын энэ өдөр онцлон тэмдэглэхэд таатай байна.

Тэрхүү сайн үйл хэргийн залгамж чанар болсон энэ цагийн шилдэг, бидний бахархалт эрхэм хүмүүсээр шинэ үеийн технологийн радио станц бүтээсэн хурандаа Л.Батболд, Р.Энхнасан, Өндөр хурдны радиотелеграфын дэлхийн аваргаас анхны хүрэл медалиг хүртсэн сургагч ахлагч Ц.Болдбаатар, доктор хурандаа М.Батхуяг, дэд хурандаа Ц.Эрдэнэтуяа, Б.Хандсүрэн, Радио спортын дэлхийн аваргын хүрэл медальт, доктор, хошууч Л.Одмаа, энхийг дэмжих ажиллагаанд анхны мөрийг гаргасан хурандаа Ч.Ерөөлцэнгэл, хурандаа Ч.Нямжаргал, Г.Болор, залуу зохион бүтээгч ахлах дэслэгч Ж.Бямбадорж, цэргийн мэргэжлийн аварга дэслэгч Б.Нангид нарын олон алдартнуудаараа бид бахархаж байна.

Тэрчлэн Зэвсэгт хүчиндээ ажил үйлс, эзэмшсэн мэргэжлийн ур чадвараараа хурандаа Ч.Оточсүрэн/ЗХЖШ/, дэд хурандаа Мөнхтүвшин /ХЗЦК/, хошууч Б.Алтангэрэл/124/, ахмад Л.Энхмандах /ТХЦК/084/, ахлах дэслэгч Д.Чулуунбаатар/013/, дэслэгч С.Жамба/АЦК/065/, сургагч ахлагч П.Баттөр /БХИС/, ахлах ахлагч Д.Пүрэвдорж /ХЗЦК/119/, ахлагч Б.Мөнхбат /БИЦУГ/339/, дэд ахлагч Тамир /189/ бусдыгаа хошуучилж байгаа ба Зэвсэгт хүчний цэргийн холбооны бэлэн байдал, шинэчлэлт хөгжлийн төлөө мөр зэрэгцэн өргөсөн тангарагтаа чин үнэнчээр зүтгэж яваа офицер, ахлагч, ажилтан алба хаагч нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлж.

Баярын энэ өдөр Цэргийн холбооны 100 жил дахин давтагдашгүй олон чухал онцлог үйл явдлуудаас эргэн дурсахад:

- Халхын голын байлдаан болон чөлөөлөх дайны холбоог зохион байгуулж, хангасан;
- Дэлхийн дайны дараах энх цагийн бүтээн байгуулалтад аймаг, сумуудын хоорондох агаарын баганат шугамыг барьж байгуулсан;

□ Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэсэн улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын холбоог нэг чигийн радио релейний шугамаар байгуулсан;

□ Олон улсын хамтарсан сургууль, уралдаан тэмцээн, хээрийн сургууль, дадлагын холбоо, мэдээллийг өөрийн систем, хэрэгслийн онцлогт нь тохируулан зохион байгуулсан;

□ Цэргийн холбоочид олон улсын энхийг дэмжих ажиллагааны, түүний дотор Афганистан, Ирак, БНӨСУ-д явагдаж буй энхийг дэмжих ажиллагааны газар орон дээрээс эх оронтойгоо богино долгионы станцаар 5200-10800 километр хол зайд холбоо тогтоосон;

□ Ази, Номхон далайн орнуудын холбоочдын харилцан нийцлийн сургуулийн явцад өөрийн улсын радио холбооны хэрэгслүүдээр 12 улстай холбоо тогтоож байсан зэрэг олон арван амжилтыг бахархал дүүрэн илтгэж болох юм.

Тиймээс цэргийн холбооны 100 жилийн түүх нь Монгол Улсын, түүний дотор Зэвсэгт хүчний түүхийн салшгүй хэсэг байсан гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Өнөөдөр Зэвсэгт хүчний холбоо, цэргийн удирдлагын автоматжуулсан систем, хэрэгслийг дайн, зэвсэгт тэмцлийг явуулах, тэр тусмаа кибер аюулгүй байдлыг хангах гол хүч хэрэгсэл болгон ашиглах хандлагатай байна.

Зэвсэгт хүчний холбоо, цэргийн удирдлагын автоматжуулсан систем, хэрэгслийн бэлэн байдлыг хангах, орчин үеийн тоон технологиор шинэчлэх, мэдээллийн сан, програм хангамжуудыг шинээр зохион ашиглах, холбоочдын үүрэг гүйцэтгэх чадавч, мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх, холбоо, мэдээллийн техник хэрэгсэлд хийгдэх засвар, техник үйлчилгээг технологийн дагуу хийх, Зэвсэгт хүчинд төрийн болон цэргийн нууцыг чанд хадгалах, хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, Зэвсэгт хүчний анги, салбарууд, гадаадад үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багуудтай мэдээллийн харилцааг зохион байгуулах зэрэг олон зорилтууд өдөр тутам тавигдаж байна.

Бодит байдал дээр өнөөдөр Зэвсэгт хүчинд ашиглаж байгаа хээрийн хөдөлгөөнт холбооны аналого холбооны техник хэрэгслийг орчин үеийн тоон техник технологиор, байнгын холбоог шилэн кабелиар бүрэн шинэчлэх шаардлагатай гэдгийг ч бид сайтар мэдэрч ойлгож, шинэчлэхийн төлөө хөдөлмөрлөж байна.

Энэ бүгдээс үндэслэн "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги 2030 хөтөлбөр"-ийн хүрээнд "Зэвсэгт хүчний холбоо, мэдээллийн техник технологийг шинэчлэх бодлого"-ыг Батлан хамгаалахын сайдаар батлуулан Зэвсэгт хүчний бүхий л нэгтгэл, анги, салбарыг хамарсан "Нэгдсэн сүлжээ - шилэн кабель", "Хээрийн хөдөлгөөнт радио холбоо" зэрэг төслийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна.

Зэвсэгт хүчний холбоочдын үүрэг, хариуцлага улам өргөжиж, гадаад улс оронд үүрэг гүйцэтгэж байгаа Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн тухайн орноос өөрийн орон, Зэвсэгт хүчинтэй байнгын холбоог зохион байгуулах хариуцлагатай үүргийг гүйцэтгэж, 2000 оноос эхлэн АНУ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн Цэргийн командлагын олон үндэстний холбооны харилцан ажиллагааны сургуульд идэвхтэй оролцож, харилцан туршлага солилцож,

олон улсын цэрэг, иргэний байгууллагуудтай харилцан ажилласнаар мэргэжлийн ур чадвар, дадлага, туршлагаа улам бүр дээшлүүлж ирлээ. Мөн манай Зэвсэгт хүчин жил бүр АНУ-тай хамтарсан "Хааны эрэлд", Энэтхэг Улсын хамтарсан "Нүүдэлчин заан", ОХУ-тай хамтарсан "Сэлэнгэ", олон улсын морин уралдааны "Аравт" тэмцээн зэрэг сургууль, уралдаан тэмцээний удирдлага, холбоо, мэдээллийн системийг дэлгэн байгуулж, холбоочид үүргээ мадаггүй сайн биелүүлж байгааг тэмдэглэн хэлэхэд сайхан байна.

Цэргийн холбоочдын бахархал болсон энэ өдрийг орчин цагийн Цэргийн холбоо үүсэн байгуулагдсан өдөр болгон жил бүр тэмдэглэх шийдвэрийг Батлан хамгаалахын сайдын 2001 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 65 дугаар тушаалаар баталгаажуулсан нь цэргийн холбоочдод үзүүлсэн том хүндэтгэл юм.

Түүхт ойг тэмдэглэх гэдэг нь тухайн салбарт ажиллагсдын амжилт, хөдөлмөр бүтээлийг нийтэд алдаршуулах, мэргэжил нэгт нөхдөөсөө туршлага солилцох, шинийг сурах, эрэлхийлэх, шинэ үеийнхний ярьдгаар бол шинэ энерги цуглуулах ач холбогдолтой арга хэмжээ гэж бид ойлгох ёстой.



Бид ойгоо угтаж, 100 жил бүтээсэн түүхийн үнэнийг тодотгон алдаршуулах, гурван үеийн алтан хэлхээ холбоог бэхжүүлэх, цэргийн холбоочдын үнэт зүйлс, хамт олны бүтэцл үйл хэргийг сурталчлан таниулах, ирээдүйн зорилго, зорилтоо тодорхойлох, үйл ажиллагаандаа шинэ ажил үйлчилгээг нэвтрүүлэх, бүтээх, байгуулах зэрэг олон арга хэмжээг зохион байгууллаа.

Үүнд:

- Цэргийн холбоо, мэдээллийн технологийн бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.

- Цэргийн холбооны түүхийн 1, онол арга зүйн 4 номыг бүтээсэн.
- Монгол цэргийн инженерийн бүтээсэн Р-140М, Р-107М станцыг орлох шинэ төрлийн станцыг бий болгон туршиж байна.

- Цэргийн холбоочдын цогцолбор тэмцээнийг цахимаар зохион байгууллаа.
- Цэргийн холбооны дурсгалын медальтай боллоо.
- "Цэргийн холбооны 100 жил" баримтат киног бүтээлээ.
- Холбооны Орхон" зангилгааны засвар, сүлжээ, холбооны системийн шинэчлэлт зэрэг олон бүтээлч ажлаар түүнд ойдoo бэлэг барьж байна.

Цэргийн холбооны хөгжил дэвшлийн төлөө оюуны, санхүүгийн, материаллаг, арга зүйн болон сэтгэл санааны дэмжлэг үзүүлж, төлөвлөсөн бүхнийгээ амжилттай хэрэгжүүлэхэд хүчин зүтгэсэн олон улсын бүх холбоочдоо халуун талархал илэрхийлж.

Зэвсэгт хүчний холбоо, цэргийн удирдлагын системийн



хөгжлийн тухай асуудал бол олон улсын жишиг, стандартад нийцсэн цэргийн технологи бүхий оюунлаг систем, хэрэгслийг хөгжүүлэхэд оршино. Учир нь, зэвсэгт тэмцэл явуулах, бэлтгэлээ хангахын тулд удирдлагын систем, хэрэгслийг хиймэл оюун ухаан, виртуаль сэтгэлгээ, робот техниктэй хослуулан нэвтрүүлж, сүлжээнд төвлөрсөн зэвсэгт тэмцлийн арга, хэлбэрийг ашиглах онол практикийг туршин хэрэгжүүлж, цэргийг мэдээллээр давуу байдалтай байх зарчим дээр тулгуурлан хөгжүүлэхэд чиглэгдэж байна.

Зэвсэгт хүчний цэрэг, зэвсгийн системийг шинэ техник



технологиир шинэчлэх төсөл, хөтөлбөрийг олон талаас нь үндэслэл сайтай боловсруулан хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний бодит хэрэгцээг хангасан, монгол цэргийн хэрэглээнд нийцсэн, аюулгүй байдал нь хангагдсан систем, хэрэгсэл, технологитой, боловсрол, мэдлэг, ур чадвар, туршлагаараа танигдсан боловсон хүчинтэй болохын тулд бид өөрсдийн инженер, техникийн мэдлэг боловсрол, тэдний оюуны багтаамж, ур чадварыг хөгжүүлэх шаардлага тавигдаж, өөрсдөө бүтээх замыг сонгож байгаагаа тэмдэглэн хэлж.

Тиймээс Зэвсэгт хүчний цэргийн холбоо, удирдлагын автоматжуулсан систем, хэрэгслийн бэлэн байдлыг хангах, удирдлага, холбоо, мэдээллийн системийг тоон технологит бүрэн шилжүүлж, техник технологийн давуу байдлаар "эх орноо алган дээрээ байгаа юм шиг харач" зорилгыг дэвшүүлж, хэрэгжилтийг зохион байгуулахыг Цэргийн холбоо үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярын тэмдэглэлт энэ өдөр Цэргийн холбоочин - офицер, ахлагч, түрүүч, байлдагч, ажилчин алба хаагчид нартаа уриалж байна.

Баярын цахим хуралд оролцож байгаа бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид, гавьяат, алдартнууд, үе үеийн цэргийн холбоочид, эрхэм генерал, офицер, ахлагч, цэрэг, түрүүч, ажилтан алба хаагч Та бүхэнд дахин баярын мэндчилгээ дэвшүүлж, ажил үйлс тань амжилтаар дүүрэн, амьдрал тань аз жаргалаар бялхаж явахын өрөөлийг айлтгаж.

Монгол Цэргийн сүр жавхаа, цэргийн холбоочдын сулд хийморь үргэлжийн мөнхөд бадарч байх болтугай.



дэлхийн улс орнуудын хооронд мэдээлэл дамжуулах системийн хөгжилд томоохон түлхэц болсон түүхтэй.

Ардын журамт цэрэг Зөвлөлт Орос Улсын Улаан армийн ангиудын хамт Нийслэл Хүрээг чөлөөлж, Ардын засгийн Цэргийн яамыг байгуулсны дараа түүний бүрэлдэхүүнд АЖЦ-ийн холбооны ажлыг удирдан зохион байгуулах үүрэгтэй Харилцан нэвтрэлцэх хэлтсийг 1921 оны сүүлийн хагаст байгуулснаар орчин цагийн Зэвсэгт хүчний Холбооны цэрэг үүсэн байгуулагдах үндэс суурь бүрджээ.

Бахархалт түүхийн өнгөрсөн үеийг Ардын Журамт Цэргийн гол хүч 1921 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн

